

КОМПАНИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД
ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

2022.12.12

Улаанбаатар хот

“Төслийн удирдлагын үйл ажиллагаанаас - төмөр замын ашиглалт, тээвэрлэлтийн цогц үйлчилгээ үзүүлдэг” компани болж өсөн дэвших зорилго, зорилтын хүрээнд “Тээврийн хөгжлийн хөтөлбөр - 2050”, “Стратеги төлөвлөгөө - 2050” болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандaa удирдлага болгон компанийн “**2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө**”-ний хэрэгжилтийг хангах, “Тавантолгой-Гашуунсуухайт” чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж, дуусгаж хүлээн авах, туршилтын ба зүгшрүүлэх тээвэрлэлтийн ажлыг эхлүүлсний үр дүнд 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр тээврийн үйл ажиллагааны нээлтийг албан ёсоор хийсэн.

Энэхүү төслийн цогцолбор ажлын хүрээнд Тавантолгой өртөө, удирдлагын байр, уурын зуух, бие даасан цэвэр, бохир усны цэвэрлэх байгууламж, б зөрлөг ба зөрлөгийн байр, ажилчдын орон сууц болон Мандах, Зэрэглээ дэд станц, дохиолол холбоо - эрчим хүчний багц ажлууд, дохиоллын цамхагийн барилга, тэдгээрийн гадна дотно орчны тохижилт, гэрэлтүүлэг, зам талбай, авто зогсооплын талбайн ажлууд бүрэн хийгдэж, ашиглалтад орсны үндсэн дээр төмөр замын суурь бүтцийн болон тээврийн үйл ажиллагаа хэвийн үргэлжилж, цаашлаад, гашуунсуухайт өртөөний 3 объект, байгууламж дээр захиалагчийн хяналт гүйцэтгэж байна.

Хөдлөх бүрэлдэхүүний зүтгүүр ба вагоны депогийн барилгын ажил 70 хувьтай байгаа бол тоног төхөөрөмж, гар багаж, хэмжих хэрэгслийн явц дундын гүйцэтгэл 54 хувьтай, мөн шилжүүлэн ачих терминал, түүхий нүүрс ачих логистик төвийн төслийг төлөвлөгөө, графикийн дагуу ажлын чанар, стандарт, аюулгүй байдлыг эрхэмлэн гүйцэтгэж байна.

Төмөр замын суурь бүтцийн ашиглалт, ачаа, тээвэрлэлтийн цогц үйлчилгээ болон томоохон бүтээн байгуулалтын төслүүдийг амжилттай хэрэгжүүлэх зорилго, зорилтыг тавьсан компанийн 2022 оны үйл ажиллагаа төлөвлөгөөнд нийт 10 бүлэг, 20 зүйл, 76 заалт бүхий ажил, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх үндсэн болон дэмжих чиг үүрэгтэй газар, алба, хэлтэс /нэгж/-ийн хийж хэрэгжүүлсэн 644 хуудас тайлан, материалтай танилцсаны үндсэн дээр дараах **дүгнэлт, зөвлөмжийг** гаргаж байна.

Нэг. Захиргаа, удирдлага, зохион байгуулалтын хүрээнд

1. “Тавантолгой төмөр зам” Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулж, компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцүүлэн, ТУЗ-ийн тайланд үнэлэлт дүгнэлт өгсөн байна.

2. Төлөөлөн удирдах зөвлөл (2022.09.28)-ийн 15 дугаар тогтоолоор компанийн 2021 оны Аудитаар баталгаажсан “зөрчилгүй” санхүүгийн тайлан, 2021 оны жилийн эцсийн болон 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайланда Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын алба (2022.07.20)-ны дүгнэлтийг тус тус үндэслэн Гүйцэтгэх захиралтай байгуулсан 2021.08.23-ны өдрийн КГ-01/45/01 дугаар бүхий контрактын биелэлтийг “Сайн” гэж дүгнэсэн.

3. ТУЗ-ийн хурлыг 8 удаа зохион байгуулж, 20 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, хэлэлцсэн асуудлаар нийт 17 тогтоол, 1 хурлын тэмдэглэл гарч хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

4. “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 27 дугаар тогтоол, 2022 оны 10 дугаар тогтоолуудыг үндэслэн Гүйцэтгэх захирлын 2022 оны А/09 дүгээр тушаалаар “Компанийн орон тооны зохион байгуулалт, албан тушаалын зэрэглэл, цалингийн хэмжээний дээд хязгаар”-ыг шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Өнөөдөр Гүйцэтгэх захирал, Ерөнхий инженер, 6 алба, газар, 23 хэлтэс болон үндсэн 638 ажилтан, албан хаагч, хөлсөөр ажиллах гэрээтэй 30 хүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

5. Гүйцэтгэх захирлын зөвлөлийн хуралдаан 11 удаа зохион байгуулагдаж, 44 асуудал, 29 заавар, журмыг хэлэлцэн баталж, хурлаас гарсан шийдвэрийг болон “Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах тухай” тоот албан даалгаварт заасан 9 бүлэг, 58 ажил, арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж ирсэн байна.

6. Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хэвийн тогтвортой явуулах, үүрэг хариуцлага, сахилга батыг сайжруулах, Гүйцэтгэх

захирлын 853 тушаалыг албажуулан гаргасан, үүнээс үйл ажиллагаатай холбоотой 183 тушаал, хүний нөөцтэй холбоотой 670 тушаал тус тус гарсан байна.

7. Гүйцэтгэх захирлын "А" тушаал 183 батлагдсанаас нийт тушаалын 23 хувийг ажлын хэсэг, бүрэлдэхүүн комисс, хороо, баг байгуулах, 49 хувийг журам, заавар, загвар, горим батлах тухай, 28 хувийг бусад тушаалууд эзэлж байна.

8. Нийт 40 дотоод томилолт, 11 гадаад томилолтын удирдамж гарч, **биелэлтийг нэгтгэн** үзвэл, тайлант хугацаанд давхардсан тоогоор 177 ажилтан 168 өдөр 1344 цаг томилолтоор ажиллаж, хүндэтгэн үзэх шалтгааны улмаас 6 ажилтан томилолтоор яваагүй, харин албан томилолтын 35 хувийг "Тавантолгой-Гашуунсуухайт" төмөр замын төслийн талбай, 25 хувийг "Богдхан төмөр" замын төслийн талбай, 37 хувь нь гадны байгууллагад туршлага судлах, 3 хувь нь томилолтоор зорчоогүй ажилтны томилолт эзэлж байна.

9. Төв, Гэрэгэ оффис болон "Тавантолгой" кемп, өртөө, зөвлөгийн байршилд мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний төлөвлөлт зохион байгуулалтыг хийж, тэдгээрийн хэвийн үйл ажиллагааг хангах, зөвлөгөө өгөх ажлууд хийгдсэн.

10. Суурин болон зөөврийн компьютерууд, өнгөт болон олон үйлдэлт принтер, онлайн хурлын систем, албан хэрэг хөтлөлтийн Эйбл систем, албан и-мэйл, вэб хуудас, дотоод болон интернэт сүлжээ, суурин утас, дотуур холбооны хэвийн үйл ажиллагааг хангаж, давхардсан тоогоор 650 гаруй хэрэглэгчдэд техник хангамжийн болон системийн тохируулга хийж, тоног төхөөрөмжид баталгаат засварын төвөөр ажил үйлчилгээ үзүүлж ирсэн.

11. Серверийн аюулгүй ажиллагаанд тогтмол хяналт тавьж, өдөр тутмын хандалтын болон бусад логуудыг шалган ажиллаж, дотно ба гадна сүлжээний трафикийг халдлагаас сэргийлэх ажлуудыг дэс дараатайгаар явуулж, мөн "Тавантолгой" өртөөний утсан холбоо болон интернэт холболтын шийдлийн судалгааны ажлыг ЭХДХХ-тэй хамтран хэрэгжүүлсэн.

12. Юнител групптэй хамтран интернэт урсгалын хяналт, Коллпро компанийтай хамтран утсан холбооны ашиглалт, тохируулга, хяналтын ажлыг гүйцэтгэсэн.

Дээд байгууллагын тогтоол, шийдвэр

- Хэрэгжүүлж буй төсөлтэй холбогдуулан Төмөр замын тухай хууль, Засгийн газрын "2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т туссан ажил, арга хэмжээг үйл ажиллагаандаа тусган зохион байгуулж, 2018-2022 онд удирдах дээд байгууллагаас ирүүлсэн 36 тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж иржээ.
- "Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлж, хөгжлийн төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай" 2022 оны 01 тоот албан даалгаварт тусгагдсан харьяалах арга хэмжээний хүрээнд:
 - а. ЗТХЯ-нд гүйцэтгэлийн тайланг маягтын дагуу нийт 8 удаа хүргүүлж ажилласан;
 - б. "Гашуунсуухайт-Ганцмод" хилийн боомтын хилийн төмөр замын барилгын ажлыг 2022 оны 05-р сард багтаан эхлүүлэх, энэ хүрээнд боомтын хилийн төмөр замын хил нэвтрэх цэгийг тохиролцох асуудлаар "Тавантолгой төмөр зам" ХХК, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ний зүгээс БНХАУ-ын "Чайна Энержи олон улсын хөгжил", "Чайна Энержи", "Баошэн төмөр зам", "Хятадын зураг төслийн групп" компаниудтай цахимаар болон 10 удаагийн хурал, уулзалтыг зохион байгуулж ирсний дүнд талууд "хилийн төмөр замын холболт"-ын асуудлаар хэлэлцэн хос царигийн төмөр замыг хоёр улсад харилцан оруулахаар урьдчилсан байдлаар тохиролцсон;
 - в. Хурлын танилцуулга, материалыг тухай бүрд холбогдох яамдад илгээж, чиглэл авч ажиллан хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг СЯ, ЗТХЯ, ГХЯ-нд тус тус хүргүүлсэн;
 - г. Монгол Улс, БНХАУ хооронд А/21-1089 дугаартай тоот бичгээр хилийн төмөр замын холболтын цэгийг тохирсон;
- Ерөнхий сайд (2022.03.04)-ын 34 тоот захирамжаар "Гашуунсуухайт-Ганцмод" чиглэлийн төмөр замын асуудлаар БНХАУ-ын Хөгжил, шинэтгэлийн хороотой яриа, хэлэлцээр хийх Ажлын хэсгийг, 35 тоот захирамж (2022.03.07)-аар хилийн "Гашуунсуухайт-Ганцмод" боомтын төмөр зам, шилжүүлэн ачих байгууламжийг цогцоор барих ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах үүрэгтэй Ажлын хэсгийг тус тус байгуулсан;
- "Тавантолгой төмөр зам" ХХК нь "Чайна энержи олон улсын хөгжил", "Баошэн төмөр зам" ХХК (2022.03.14)-тай уулзалт зохион байгуулж, бүтээн байгуулалтын техникийн

- асуудлууд, төслийн хөрөнгө оруулалт, нүүрсний худалдааны талаар хэлэлцэж, үр дүнг Засгийн газарт танилцуулсан;
- Засгийн газрын 16 дугаар хуралдааны тэмдэглэл /2022.03.16/-д Хятадын “Чайна Энержи олон улсын хөгжил” ХХК-тай хэлэлцээр хийх, хятадын талаас манай компанийг “ЭТТ” ХК-тай нүүрсний худалдааны асуудлаар уулзалт зохион байгуулж өгөхийг хүссэний дагуу цахим хурал /2022.03.17/-ыг зохион байгуулсан;
 - БНХАУ-ын “Төмөр замын зураг төслийн групп”-ийн мэргэжлийн ажлын хэсэгтэй анхны цахим хурлыг хийж, талууд “Төмөр замын зураг төслийн групп”-ээр холболтын төмөр замын зураг төслийг хийлгэхээр санал нэгдсэн;
 - “Чайна Энержи олон улсын хөгжил” компаниас Монголын талаас явуулсан ерөнхий хэлэлцээрт /2022.07.26/ саналаа тусгаж, “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой төмөр зам” ХХК-үүд хэлэлцээрийн төслийг эцэслэж, саналаа нэгтгэсэн;
 - “Харилцан ойлголцлын санамж бичиг” (2022.08.08)-т гарын үсэг зурж, Монгол Улсын “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой төмөр зам” ХХК болон БНХАУ-ын “Чайна Энержи” ХХК хооронд “Гашуунсухайт-Ганцмод боомтын төмөр зам, нүүрс худалдах, худалдан авах ерөнхий хэлэлцээр”-ийг байгуулж, монгол, хятад, англи 3 улсын хэл дээр гарын үсэг зурж, баталгаажуулсан.

Хууль, эрх зүй болон архив, бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлт, өргөдөл гомдол

- Эрх бүхий 24 албан тушаалтны 2021 оны ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд гаргуулж, шалган хүлээж авах ажлыг гүйцэтгэж, тайланг нэгтгэн “Эрдэнэс Тавантолгой” ХК болон АТГ-т хүргүүлсэн.
- Гүйцэтгэх захирлын болон Үнэлгээний хорооны гишүүдээс гаргасан ашиг сонирхлын 110 мэдэгдлийг тухай бүр PDF файл болгон компанийн шилэн дансанд дахь мэдээлэлд байршуулан ажилласан.
- ХЭЗХ-ээс “Фидикийн түлхүүр гардуулах төслийн инженеринг, худалдан авалт болон барилгын гэрээний нөхцөл” номын эх бэлтгэлд редакц хийж, 500 хувийг хэвлүүлж санхүүгийн газарт хүлээлгэн өгсөн.
- Архивт байгаа 2008-2022 оны Зүүнбаян чиглэлийн болон Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн ажлын тайлангийн бичиг баримтууд, компанийн байнга хадгалах хадгаламжийн нэгжийн бүрдлийг хүлээн авч, бичиг баримтуудыг скайнердах, цахим архив үүсгэх, хадгаламжийн нэгж үүсгэх, архивын нэгдсэн бүртгэл үүсгэх, нөхөн бүрдүүлэлт хийсэн.
- Архивт байнга хадгалагдах 12,226 нэгж, түр хадгалагдах 620 нэгж, 70 жил хадгалагдах 36 хадгаламжийн нэгж хадгалагдаж, 2009-2022 оны баримт болох 12,226 баримт бичгийг сканердаж, 742 ширхэг HARD DICK, CD дээр хадгалж, цахим сан үүсгэсэн.
- Баримт бичгийн эргэлтийн мэдээг сар бүр гаргаж, хугацаатай албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж, нэгжийн бичиг хэргийн ажилтан болон холбогдох ажилтанд танилцуулж, анхааруулан, шийдвэрлэлтийн мэдээг гаргасан.
- 196 өргөдөл, гомдол ирснээс тэтгэмж тусламж хүссэн 36, ажлаас чөлөөлөгдөх хүсэлт 57, цалинтай болон цалингүй чөлөө олгохыг хүссэн 41, сургалтын төлбөрт дэмжлэг хүссэн 4, шилжин ажиллах тухай 13, хүүхэд асрах чөлөө дуусгаж, ажилд эргэн орох хүсэлт гаргасан 3, ажлын газрын тодорхойлолт гаргуулахаар болон бусад асуудлаар ирүүлсэн өргөдөл 33, гадны байгууллага, иргэнээс 9 өргөдлийг зохих журмын дагуу шийдвэрлэн ажиллажээ.

Боловсон хүчин, сургалт мэдээлэл, хамтын ажиллагааны талаар

- Хүний нөөцийн мэдээллийн нэгдсэн систем нэвтрүүлэх ажлыг 2022 оны 02-р сараас эхлүүлэн үе шаттайгаар хэрэгжүүлж, ажил 90 хувийн гүйцэтгэлтэй байна.
- “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2021-2025 онд хэрэгжүүлэх “A6-20” дунд хугацааны бизнес төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлж буй төслүүдийн танилцуулга, нээлттэй ажлын байрны болон “ETT Events-2022” өдөрлөгт оролцож, компанийн үйл ажиллагааг олон нийтэд танилцуулсан.
- ШУА, “Монголын төмөр зам” ТӨХК, УБТЗ ХНН түүний харьяа Төмөр замын дээд сургууль, Төмөр замын политехник коллеж, Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв, “Болд төмөр Ерөө гол” ХХК, “Зүүнбаян төмөр зам” ХХК болон БНСУ-ын “Солонгосын төмөр замын техникийн корпорац” /KRTC/, АНУ-ын “Үндэсний төмөр

- замын тоног төхөөрөмж” компанитай хамтран ажиллах “Санамж бичиг” байгуулан ажиллаж ирсэн.
- “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын нээлтийн үйл ажиллагаа (2022.09.09) амжилттай зохион байгуулав. Нээлтийн бэлтгэл ажлын хурээнд:
 - Үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээ, нээлттэй ажлын байрны зар, тендерийн урилга, богино хэмжээний видео контент болон 10 минутын нэвтрүүлэг, эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлүүдийн видео, фото постер, төмөр замын аюултай бүсийн талаарх ойлголт, компанийн албан ёсны вэбсайт болон нийгмийн сүлжээний хуудсаар түгээж, хандалтыг хянах, сэтгүүлчдийг бодит мэдээллээр хангах ажлыг зохион байгуулан ажилласан.
 - “Төмөр замын салбарын хөгжлийн тулгамдсан асуудлууд” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг 2022.02.25-ны өдөр МУИС дээр зохион байгуулж, ЭЗХЯ, ШУА, МУИС-ийн Хууль зүйн сургууль, ШУТИС-ийн Механик, тээврийн сургууль, ТЗДС, Улаанбаатар Эрдэм их сургууль, Шихихутаг их сургууль зэрэг сургалт, эрдэс шинжилгээний байгууллагууд хамтран ажилласан.
 - УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Бoomтын сэргэлтийн хүрээнд СЯ, ЭЗХЯ, ЗТХЯ-наас 2022.03.28-ны өдөр зохион байгуулсан “Монголын эдийн засгийн чуулган-2022”-д Гүйцэтгэх захирал Н.Удаанжаргал оролцож, Тавантолгой-Гашуунсухайтын төмөр замын төслийн ажлын явцын талаар танилцуулсан.
 - Бoomтод “Гашуунсухайт шилжүүлэн ачих терминал”-ын бүтээн байгуулалтын нээлтийн үйл ажиллагаанд Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ болон холбогдох сайд, УИХ-ын гишүүд, аймаг, орон нутгийн удирдлагууд, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдэд хэвлэлийн мэдээ, төслийн танилцуулга, бодит мэдээллээр ханган ажиллав.

Хангамж, кемп үйлчилгээ, худалдан авах ажиллагаа

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил худалдан авах тухай хууль, ТУЗ болон Гүйцэтгэх захирлын баталсан Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг tender.gov.mn цахим сайтад байршуулан, нийт 111 нэр төрлийн бараа, ажил үйлчилгээ худалдан авахаас нээлттэй тендер-28, харьцуулалт-29, шууд худалдан авалт-54-ийг зохион байгуулсан.
- “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн дагуу зарим ажлууд цуцлагдаж, 2022 онд 15.0 тэрбум төгрөгийн худалдан авалт хийхээс өмнөх тендерийн үлдэгдэл төлбөр хийх, бараа хүлээн авах, төслийн талбайд хангарт хийх зэрэг ажлуудыг гүйцэтгэж, бүгд 7,089,541.330 төгрөгийн буюу 6 нээлттэй тендер, 6 харьцуулалтын тендер, 9 шууд худалдан авалт хийсэн байна.
- Инженер, техникийн ажилтны ажиллаж амьдрах нөхцөл боломжийг хангах үүднээс Тавантолгой, Цэций, Дундын, Гашуунсухайт, Төв болон “Түүхий нүүрс ачих логистикийн төв” барихад шаардлагатай кемп, оффис, амралтын байр, гэр сууцыг байгуулж, засвар үйлчилгээ, захиалга, цэвэрлэгээ ариутгал, халдвартгуйжүүлэлтийг тогтмол явуулж ирсэн байна.
- Компанийн эзэмшилийн автомашинд Өмнөговь аймгийн явуулын станцаар оношилгоо, үзлэг хийлгэж, жолооч нарын хөдөлмөр, хөдөлгөөний аюулгүй байдалд дүгнэлт гаргаж, илэрсэн зөрчлийг арилгуулж ирсэн байна.
- Кемп үйлчилгээ нь тавантолгой өртөө, удирдлагын байр, вагоний үзлэгийн байр, зам засварын байр, депо засварын байранд тохижилт, цэвэрлэгээ үйлчилгээ, сантехник, цахилгаан мужааны засвар үйлчилгээний ажлуудыг хийж гүйцэтгэн, 2 уурын зуух, 4 худаг, 1 цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна.

Харуул хамгаалалт, эрүүл мэнд, хөдөлмөр хамгаалал

- Хөдөлмөрийн сахилга бат, дэг журам сахиулах, аюулгүй байдалд хяналт тавих, гэмт хэрэг, зэрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 9 объектод харуул хамгаалалтын 12 дүрэм, журам, зааврыг батлуулан ажиллаж байна.
- Төслийн талбайд ахлах ажилтнууд 3032 хүн/цаг, хамгаалалтын ажилтнууд 12 цагаар 12131 хүн/цаг тасралтгүй 24 цагаар үүрэг гүйцэтгэж, давхардсан тоогоор нийт 1251 инженер, техникийн ажилтнуудад захирал /2021.11.03/-ын 2 тоот “Хөдөлмөр зохион

- байгуулалт, ажлын байрны дэг журам сайжруулах" албан даалгаврыг танилцуулж ажилласан.
- Давхардсан тоогоор үндсэн 46, гэрээт 50 автомашиныг Улаанбаатар хот руу ээлжийн ажилтнуудыг тээвэрлэх үед аюулгүйн зааварчилгаа өгч ажиллажээ.
 - ЦЕГ-ын Бүртгэл хяналтын төвийн "галт зэвсэг, тусгай хэрэгсэл худалдан авах журам"-ын дагуу хамгаалалтад ашиглах хийн буу, тусгай хэрэгслийн иж бүрдэл, техник үзүүлэлтийн судалгааг бэлтгэсэн.
 - Инженер, техникийн ажилтнуудад эмчийн урьдчилсан үзлэг хийж, ажилтан бүрд эрүүл мэндийн 540 карт нээж, тэдэнд эмийн болон анхан шатны эмнэлгийн тусламж үйлчилгээ, зөвлөгөө өгөх ажлыг тогтмолжуулж, эм тарианы зарцуулалтыг сар бүр тайлагнаж ирсэн байна.
 - Ажилтнуудын эрүүл мэнд, бие бялдрын хөгжил болон спортын ур чадварыг дээшлүүлэх, хамт олноороо чөлөөт цагаараа спортоор хичээллэж, ажлын эрч хүчийг нэмэгдүүлэхэд анхааран ажиллаж, Ерөнхий инженерийн нэрэмжит 3x3 сагсан бөмбөгийн тэмцээнийг жил бүр зохион байгуулж, хэвшсэн байна.
 - Gan спорт төвд "Эрдэнэс Тавантолгой" ХК-аас зохион байгуулдаг "Бага олимп 2022" спортын наадамд манай хамт олон амжилт (IY байр)-тай оролцож ирсэн.
 - Гүйцэтгэх захирлын A/82 тоот тушаалаар "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо"-г шинэчлэн баталж, ХАБЭА-н бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.
 - 11-р сарын байдлаар гэмтэл бэртлийн зэрэг LTIFR-0 тэнцүү байгаа нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг сайн хангаж ажилласны үр дүн, энэ чиглэлд аюулгүй ажиллагааны яриа, танилцуулга тогтмолжиж, давтагдсан тоогоор 3342 ажилтан хамрагдаж ирсэн байна.
 - Тушаал, зааврыг нийт инженер, ажилтан, ажилчдад тогтмол танилцуулж, нэгдсэн 6 удаагийн сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулан 441 ажилтныг хамруулж, үүнээс ээлж бүрт ХАБЭА-н мэргэжилтнүүд зохион байгуулж, 477 ажилтан оролцсон байна.

Хоёр. Тээврийн статистик, систем хөгжүүлэлт

1. ЗТХЯ-ны A/154 тоот тушаалаар батлагдсан 29 төрлийн маягт, компанийн "Тээврийн үндсэн үзүүлэлтийн мэдээ, тайлан гаргах журам"-д заасан анхан шатны 9 төрлийн бичиг баримтыг цуглуулах, тэдгээрт боловсруулалт хийн тайлан гаргах, тайлагнах үйл ажиллагааг хөдөлгөөн зохион байгуулалт, ачаа тээвэр - логистик, зүтгүүр, вагоны аж ахуйд үйлдэж, 7 хоног бүр цахимаар болон эх хувиар татан авч, боловсруулсан баримтыг холбогдох газруудад хүргүүлэн ажиллаж байна.

2. Тээврийн статистик, систем хөгжүүлэлтийн анхан шатны бичиг баримт боловсруулалт, мэдээ, тайлан гаргалтын үйл ажиллагааг MS Excel программ хангамж ашиглан гүйцэтгэж, 2021 онд батлагдсан программ хангамжийн техникийн даалгаварт дахин боловсруулалт, тооцоо, судалгааны ажлууд хийгдэж байна.

3. Төмөр замын байгууллагуудын харилцан мэдээлэл солилцох журмын хүрээнд мэдээ, тайланг хэрхэн гаргах, мэдээлэл хэрхэн солилцох талаар ГТХЗНТ-тэй зөвшилцэж, зам, тээврийн салбарын нэгдсэн пратформ Veritech ERP программын 2 удаагийн зөвлөгөөнд хамрагдан, цаашид ЗТХЯ-ны ГТХЗНТ-д мэдээ дамжуулах, компанийн дотооддоо ашиглах боломж, давуу, сүл талыг судлан ажиллаж байна.

Гурав. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт ба хяналт

ТНАЛТ төслийг холбогдох хууль, дүрэм, журам, норм, стандартад нийцүүлэн гүйцэтгэсэн:

1. Бүтээн байгуулалтын ажлын мастер төлөвлөгөөний дагуу 2023 оны 12-р сард ашиглалтад оруулах зорилт тавьж, 2022 оны 7 дугаар сараас туршилтын тээвэр эхлүүлэх шаардлагад нийцүүлэн нүүрсийг авто ачигч /ковш/-аар ачих механизсан терминал байгуулахаар ажиллаж байна.

2. Зам барилгын ажлын дэвсгэр дагуух огтлол ба хөндлөн огтлолын, шуудууны зураг болон барилга байгууламжийн зураг төсөл, хиймэл төхөөрөмжийн байршлын тооцоо, ус зүйн судалгаа, замын дээд бүтцийн тооцоолол, газар ашиглалт, технологийн замын зураг, техникийн шаардлага, ажлын тоо хэмжээ, зурvas газрын зураг, зураглалыг гүйцэтгэсэн.

3. Төслийн ТЭЗҮ-ийг боловсруулж, гэрээ, хэлэлцээрээр Ерөнхий гүйцэтгэгч төслийн 6 багц ажлыг 28 сарын хугацаанд бүрэн гүйцэтгэхээр ажиллаж байна.

4. Түр ачилтын талбайн барилгын ажлын зураг, газар шорооны хэмжээг стандартын дагуу тооцож, ачилтын талбайн тойрог замын ПК6+880-ПК7+814 км-ийн урд талд, гадна талын замын тэнхлэгээс 1920 мм /техник ашиглалтын журам/-ийн зайд байрлуулах, ачилтын тавцангийн оврын хэмжээг өндөр тавцангийн хэмжээгээр зам төмрийн толгойн түвшнээс дээш 1100 мм өндөр, тавцангийн урт нь 934 м, өргөн 100 м байхаар төлөвлөсөн.

5. Төслийн I нэгж ажлын явцыг хянан баталгаажуулах, гүйцэтгэгчид аргазүйн зөвлөгөө өгч ажилласны үр дүнд төслийн гүйцэтгэл 44.91 хувьтай байна. Уг төслийн нийт 6 багц ажлыг үзүүлбэл:

Багц ажлууд	Хэрэгжиж буй ажлын хувь, хэмжээ	Хэрэгжсэн ажлын гүйцэтгэлийн хувь хэмжээ
Багц ажил I	Сэндвичин хавтангийн тээвэрлэлт, TLO вагонд ачигчийн тээврийн ажил үргэлжилж байгаа;	Нүүрс барьцаалдуулагч байгууламжийн суурийн ажил бүрэн дууссан (100%)
Багц ажил II	Түшиц ханын А, D тэнхлэгийн арматурчлал, бетон цутгалтын;	Бутлуурын суурийн ажил дууссан
Багц ажил III	- CV312 суурийн арматур угсралт, бэлтгэл бетон цутгалтын ажил, - Буцаан дүүргэлт 5-р үе дээр, - CV112 суурийн буцаан дүүргэлтийн, - CV111 суурийн бетон цутгалтын, - CV113 суурийн буцаан дүүргэлтийн, - ST112 суурийн баганын бетон цутгалтын ажил,	
Багц ажил IV	- SK211 С болон D тэнхлэгийн суурийн буцаан дүүргэлтийн ажлын 5-р үе, - RC311 E, F, RC312 A, B тэнхлэгүүдийн суурийн буцаан дүүргэлт, нягтрнуулалт, - SK211 C тэнхлэгийн суурийн буцаан дүүргэлтийн 5-р үе дээр,	
Багц ажил V	- Удирдлагын барилгын парапетны бетон цутгалтын ажил эхэлсэн, - Засварын төвийн цутгамал ханын арматурчлал, хэв хашмал, угсралтын ажил, - Уурын зуухны барилгын гадна 375мм, дотно 120 мм блок ханын өрлөг, +7.15м түвшний парапетны бетон цутгалт /тэнхлэг:X1-X5,Y3-Y4/, - Агуулахын барилгын суурийн дам нурууны дулаалгын 10 см XPS хавтан угсралтын ажил,	
Багц ажил VI	- 35/6кВ-ын дэд станцын удирдлагын байрны 1-р давхрын багана, - ДН-1, ДН-2, ДН-3, ДН-4 хучилтын бетон цутгалт болон 200мм-ийн хананы бетон цутгалт, - Кабелын худаг 1, 2, 3, 4 бетон цутгалтын ажил, - ЦДКШ-ын Л-2, Л-4 лотки суурилуулах ажил, - Трансформатор 1, 3, 4 болон ХХБ Е House-н буцаан дүүргэлтийн 4-р үе дээр тус тус үргэлжилж байна.	

“Богдхан” төмөр замын төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, ЗТХЯ-ны ШУТ-ийн дэд зөвлөл /2022.05.06/-ийн хурлаар болон магадлалын ерөнхий дүгнэлтээр магадлуулж, төслийн хүрээнд дараах ажлууд хийгдэж байна.

1. ТЭЗҮ болон бусад суурь судалгааг үндэслэн төмөр замын чиг тогтоо ажилд оролцон, эрх бүхий байгууллагад танилцуулсны үндсэн дээр Засгийн газрын 51-р тогтоолоор төслийн чигийг тогтоон өгсөн.

2. “Урбан девелопмент консалтинг групп” ХХК /2022.04.25/-тай АГГ-01/28/16 тоот дугаартай нарийвчилсан ажлын зураг төсөл боловсруулах гэрээ байгуулж, ажлын зургийн явц 80 хувийн гүйцэтгэлтэй байна.

3. FIDIC-ээс гаргасан жишиг гэрээний тухай ерөнхий ойлголтыг судлан үзэж, Гэрээний менежмент болон Red book-ийн тухай ойлголтын талаар хуулийн зөвлөх үйлчилгээний багаас олон улсын FIDIC гэрээний төлбөр, төлбөрийн нөхцөл, баталгааны талаарх зохицуулалт, зураг төсөл, туршилт, ажил хүлээж авах, маргаан шийдвэрлэлтийн асуудлуудаар сургалт авч, төслийн гүйцэтгэгч нарыг оролцуулж ирсэн.

4. МН/01, МН/03, МН/28 шийдвэрийн дагуу гүйцэтгэгч компаниудтай барилга угсралтын ажлын гэрээ болон ЕРС буюу тулхүүр гардуулах гэрээ байгуулах, холбогдох гэрээний төслүүдийг боловсруулж ажилласан байна.

5. ЗХЖШ-тай доод бүтэц, өртөө, зөрлөгийн барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээг ТТЗ-МН22/03 дугаартай байгуулж, захиалагчаас ажил эхлүүлэх мэдэгдлийг хүргүүлсэн.

6. Гүйцэтгэгч нь барилга угсралтын ажлыг эхлүүлж, төслийн талбайд газар шорооны ажил төлөвлөгөөний дагуу явуулж, гүйцэтгэл 25 хувьтай, трассын дагуух ПК 105+000 ~ ПК 142+500 хоорондох технологийн зам бүрэн хийгдсэн байна.

7. Төслийн суурь судалгааны ажлын хүрээнд ШУА-тай 7 гэрээ ба бусад байгууллагуудтай 5 буюу нийт 12 төрлийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулан, судалгааны ажлын явц 93 хувийн гүйцэтгэлтэй байна.

8. Барилга угсралтын ажлыг Рашаантаас Мааньт өртөө хүртэл гол зам нь 144.894 км, дэлгэмэл уртаараа 213.3 км төмөр зам байхаар төлөвлөж, урьдчилсан техник эдийн засгийн үндэслэлд 6 зөрлөг, 4 өртөө, 1 суурьшилын бус, 3 эстакад, 13 дам нуруут гүүр, 3 жаазан гүүр, 2 туннел, 135 ширхэг хоолой, мал амьтны гарцыг 35 байршилд, харин зэрлэг ан амьтны нүүдлийн шилжилт хөдөлгөөнд зориулсан 9 гарцыг төлөвлөсөн байна.

9. "Урбан Девелопмент Консалтинг групп" ХХК-ийн гүйцэтгэж буй төслийн "Төмөр замын зурvas газрын зураг", "Газар шорооны ажлын зураг", "Инженер геологийн ажлын зураг", "Дээд бүтцийн ажлын зураг", "Гүүр, хоолойн ажлын зураг", "Ус зүйн тооцоолол"-ын ажлын зургудыг Захиалагчийн хяналтын хэлтэс баталгаажуулсан байна.

10. ПК105+000-ПК142+500 хүртэлх ажлын зургийг магадлуулсантай холбоотойгоор Захиалагч, Зургийн автор, "Бодхан" төмөр замын барилгын ажлын гүйцэтгэг БИЦУГ-т улаан шугмыг хүлгээгэн өгч, ПК105+000-ПК142+500 хүртэлх 37.5 км газарт газар шорооны ажлын гүйцэтгэгчээр 17 аж ахуйн нэгж ажиллаж, ажлын гүйцэтгэл 21 хувьтай байна.

11. Захиалагчийн хяналт хүрээнд:

- ПК 105-ПК 142+500 хооронд төлөвлөсөн нийт 47 байршлын ус зайлцуулах болон МАГ хоолойн, 5 байршлын төмөр бетон дам нуруут гүүрийн ажлын зургийн тоо хэмжээ, зургийн байгууллагатай зөвшилцөх, хоолойн байршил тус бүр дээр SketchUp, AutoCad, Excel программ ашиглан бетон, арматур, газар шорооны ажлын тоо хэмжээг шалгах, зураг зохиогчдод холбогдох саналыг хүргүүлсэн,
- ПК105+000-ПК142+500 хоорондын газар шорооны ажилд ашиглах 4 худгийг төлөвлөсөн, мөн судалгаа, өрөмдлөг, худгийн ажлыг хянан шийдвэрлэсэн,
- I-р худаг (ПК135+400, трассын баруун талд 850м)-ийн өрөмдлөгийн ажил дуусаж, тоноглолын ажил төлөвлөгөөний дагуу явагдаж байна,
- II худаг (ПК125+180, трассын баруун талд 1,760 км)-ийн, III худаг (ПК119+780, трассын баруун талд 580м)-ийн, IV худаг (ПК112+000, трассын баруун талд 400 м)-ийн байрлалд хайгуул, өрөмдлөгийн ажлууд тус тус хийгдэж дууссан.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төслийн зам, барилга угсралтын ажлыг дуусган 2022.09.09-нд нээлт хийж, тээврийн үйл ажиллагаа эрхлэх боломжийг бүрдүүлсэн:

1. Зарим ажлууд цар тахал, хил, гаалийн асуудлаас улбаалан нийлүүлэлт, хийгдэх ажлын хугацаа хойшилсон талаарх болон төрийн эрх бүхий байгууллагуудаас ирүүлсэн чиглэл, үүрэг даалгаврын төслийн гүйцэтгэлийг тогтмол мэдээлж ажилласан.

а. ЗТХЯ-нд төслийн явцын мэдээг цахимаар тогтмол хүргүүлж, мэдээ, тайланг 22 удаа, холбогдох албан бичгийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг 221 удаа,

б. ЗТХЯ-ны шуурхай хуралдааныг мэдээллээр хангах, төслийн гүйцэтгэлийн биелэлтийг 7 хоног тутамд боловсруулалт хийж, хуралд оролцогч удирдлагуудад 14 удаа,

в. "Эрдэнэс тавантолгой" ХК-ийн ТҮЗ-ийн 16 тогтоолоор баталсан "Эрдэнэс тавантолгой" нэгдлийн уялдааг хангах журмын 6.9 дэх заалтын хэрэгжилтийг 7 хоног тутмын 1 өдөр ба сар бүрийн 5-нд тайланг цахимаар хүргүүлж, тайлант хугацаанд 11 долоо хоногийн мэдээг хүргүүлж ажилласан байна.

2. Туршилтын тээвэр хийж эхэлсэн ч гүйцэтгэх төслийн ажил 100 хувь хүрээгүй, графикт заасан багц 5, 6-ийн ажлууд нийлүүлэлттэй холбоотойгоор **87.2 хувийн гүйцэтгэлтэй** байна.

3. Гүйцэтгэгчээс ажил гүйцэтгэх мастер төлөвлөгөө /WBS-0004/-г шинэчлэн, төлөвлөгөөний дагуу багц 1, 4 ажил /2022.12.30/-ыг багтаан дуусгахаар ажиллаж байна.

4. Гэрээний хэрэгжилтийг хангах талаар талууд 7 хоног тутам уулзалт зохион байгуулж, ажлын гүйцэтгэлийг хангуулах захиалагчийн шаардлагыг хүргүүлж ирсэн.

5. Техникийн баримт бичигт хариу хүргүүлэх, харилцааны матриц үүсгэх ажлуудыг хийж гүйцэтгэсэн мэдээтэй байна.

6. Гэрээний хаалтын ўйл ажиллагаанд шаардлагатай тоо хэмжээ, үнийн дүнгийн тооцоолол болон гэрээнд заасан ерөнхий ойлголтуудын биелэлтийг ханган, төслийн төлбөрийн хүсэлт нийт 25 удаагийн байдлаар Захиалагчид ирүүлсэн, захиалагчийн зүгээс №1-23-ыг хянан баталгаажуулжээ.

7. Геодезийн хяналт тавих, газар эзэмших эрх авахтай холбоотой трассын хамгаалалтын бүсийн кадастрын зураг гаргах, өртөө ба зөрлөгийн тээх нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх судалгааны зураг, тоо хэмжээ болон өртөөний нарийн царигийн төлөвлөлт, царигийн трассын хувилбар зураг, зураглалыг нарийвчлан гаргасан.

8. Шилжүүлэн ачих терминалын суурь бүтэц, гаалийн хяналтын талбайн ерөнхий төлөвлөгөөний ажлын зураг, ажлын тоо хэмжээ, ерөнхий төлөвлөгөө, оффисын барилга, хооллох байр, "нэг цэг"-ийн ўйлчилгээний барилга, гаражийн барилга, харуулын байрны зураг зэргийг төмөр замын төслийн ерөнхий төлөвлөлттэй уялдуулан боловсруулсан;

9. Төмөр замын улсын хилийн шугамтай огтлолцох цэгийн байршлыг тогтоох болон "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Гашуунсухайт орчмын нэгдсэн ерөнхий төлөвлөгөөнд зориулсан засгийн газрын тусгай хэрэгцээний зураг төслийг боловсруулж, хяналтын баталгаажуулалт хийгдсэн.

10. "Оюу толгой" ХХК-аас төмөр замын шугам, сүлжээнд холбогдох дэд бүтцийг барьж байгуулах, инженерийн шийдлийг боловсруулах, судалгааны ажлыг эхлүүлэх тухай 2022.02.15-ны өдөр №308/fin тоот албан бичгийг ирүүлсэн. Иймд судалгаа, инженерийн тооцоолол, урьдчилан судалгааны ажлын боловсруулалтын талаарх санал, боломжит цэгт тулгуурлан:

- "Тавантолгой-Гашуунсухайт" төмөр замын шугамын ерөнхий зураглал, Оюу толгойн уурхайд хамгийн ойр байрлах төмөр замын зураглал;
- "Шунхлай Петролеум" ХХК-ийн салаа төмөр замын хувилбар зургууд болон "Оюут-Ухаа" ХХК-ийн гаалийн хяналтын талбайн зураг төсөл;
- Гашуунсухайт өртөөнд газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих агуулах барьж, байгуулах зориулалтаар ашиглаулах талбайн судалгаа;
- Тавантолгой өртөөнөөс Тавантолгой өртөөний дэргэд байрлах "ЭТТ" ХК, "ТТ" ХХК компаниудын төлөвлөж буй талбай руу төмөр зам салаалах боломжийг судлах;
- БНХАУ-ын 1435мм царигийн төмөр зам Монгол улсын нутаг дэвсгэрт нэвтрэн терминалтай холбогдох магадлалтай урьдчилсан төмөр замын трассын байршлын хувилбар зураг төсөл;
- Тавантолгой өртөөн дэх "Рейлвай көүл менежмент" ХХК-ийн салбар төмөр замын 5 хувилбартай нарийвчилсан зураг төслүүдийг тус тус хийж гүйцэтгэсэн.

Шилжүүлэн ачих терминал төслийн газар шороо, дугуй болон дөрвөлжин хоолойн ажил 100 хувийн, харин төслийн дээд бүтцийн ажлын явц 99.43 хувийн гүйцэтгэлтэй байна.

"Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян" чиглэлийн холболтын төмөр замын төсөл:

1. Зам, барилга угсралтын ажлын санхүүжилт болон явц дундын төлбөрийн хүсэлт (IPC)-ийг баталгаажуулах, Ерөнхий гүйцэтгэгчийн холбогдох албан тушаалтнууд хамтарсан уулзалт 2 удаа хийсэн.

2. "Явц дундын төлбөр баталгаажуулах заавар"-ыг боловсруулж, холбогдох мэргэжилтэн, инженер техникийн ажилтнуудаас санал авч, Гүйцэтгэх захирлаар батлуулсан. Үүний дүнд, явц дундын төлбөр баталгаажуулах ажил хугацаа алдахгүй, үйл

ажиллагаанд оролцох ажилтнуудад ойлгомжтой, удирдлага болон холбогдох албан тушаалтанд хүргэх, хянах дарааллыг тодорхой болгосон.

3. Газар шороо болон ус өнгөртүүлэх байгууламжийн барилга угсралтын ажлууд өвлийн улиралд түр зогсолтод 82 хоног шилжиж, 3 дугаар сараас гүйцэтгэлийн явцыг үзэхэд доод бүтцийн ажил 66.81 хувь, бэлтгэл ажил 97.25 хувь, газар шорооны ажил 65.18 хувь, хоолойн ажил 19.11 хувь, дөрвөлжин хоолойн ажил 15.88 хувь, дугуй хоолойн ажил 32.18 хувь, жаазан гүүр 57.86 хувийн гүйцэтгэлтэй, нийт 806,7124.12м³ газар шорооны ажил хийгдсэн байна.

4. Оны эцэс гэхэд доод бүтцийн ажил 99.26 хувь, бэлтгэл ажил 100 хувь, газар шорооны ажил 100 хувь, хоолойн ажил 97.46 хувь, дөрвөлжин хоолойн ажил 97.15 хувь, дугуй хоолойн ажил 98.36 хувь, гүүр, төмөр зам, авто замын огтлолцлын ажил 98.67 хувь, жаазан гүүр 98.28 хувь, төмөр замын огтлолцлын ажил 100 хувь, харин дээд бүтцийн ажил 92.5 хувь, бараа материал 92.9 хувь, барилга угсралтын ажлын гүйцэтгэл 91.3 хувьтай, нийт 1.191.279.34 м³ газар шорооны ажил гүйцэтгэгдсэн байна.

5. Ерөнхий гүйцэтгэгчээс ирүүлсэн явц дундын төлбөрийн хүсэлт (IPC)-ийн Захиалагчаас баталсан нийт тоо хэмжээ, ажлын жинг гүйцэтгэл тус бүрээр шалгаж, акт үйлдсэн тоо хэмжээг инженерүүдээс хүлээн авч, тухайн гүйцэтгэлээр Захиалагчаас баталгаажуулах боломжит тоо хэмжээ, төлбөрийн дүнг тодорхойлж, холбогдох эрх бүхий албан тушаалтнуудад тухай бүрд тайлagnаж ирсэн.

6. BI-TTzb-IPC-0001, BI-TTGS-IPC-0002, BI-TTGS-IPC-0003, BI-TTGS-IPC-0004, BI-TTGS-IPC-0005, BI-TTGS-IPC-0006, BI-TTGS-IPC-0007, BI-TTGS-IPC-0008-үүд батлагдсан.

“Тавантолгой-Гашуунсухайт”, Тавантолгой-Зүүнбаян” чиглэлийн холболтын төмөр замын төсөл, “ТНАЛТ”, “Шилжүүлэн ачих терминал” төслийн **байгаль орчин, соёлын өв хамгаалах, геодези, зураг зүйн талаар орон нутагт:**

1. “Тавантолгой-Гашуунсухайт” төслийн барилга угсралтын ажилд ашигласан 33 ордын 158,47га талбайд нөхөн сэргээлт хийгдсэн.

2. Зам, барилга угсралтын ажилд ашигласан балластын 5 орд, Ухаа худаг-Гашуунсухайт төслийн үед /хуучин/ ашиглалт явуулж, нөхөн сэргээлт дутуу орхигдсон 3 ордын нөхөн сэргээлтийг гүйцэтгэх шаардлагыг Ерөнхий гүйцэтгэгчид хүргүүлэн ажилласан.

3. Холболтын төмөр замын барилга угсралтын ажилд түгээмэл тархацтай ашигт талтмалын 13 ордыг ашиглах зөвшөөрөл авч, 11 ордод ашиглалт явуулснаас 6 орд газарт нөхөн сэргээлт хийсэн, харин 3 ордын нөхөн сэргээлтийн ажлыг үргэлжлүүлж байна.

4. Суурь бүтцийн барилга угсралтын ажилд ашигласан түгээмэл тархацтай ашигт талтмалын ордуудын нөхөн сэргээлтийн явцад байнгын хяналт тавьж, шаардлагатай зөвлөмжийг хүргүүлэн ажилласан байна.

5. Шилжүүлэн ачих терминалын барилгын ажилд А/686 захирамжаар олгогдсон 2 ордыг ашиглаж, нөхөн сэргээлтийг гүйцэтгэн орон нутагт хүлээлгэн өгч, барилгын ажилд ашигласан түгээмэл тархацтай ашигт малтмалын ордуудын нөөцөд хяналт тавьж, нэмэлт гэрээг Цогцэций, Ханбогд сумын газрын албатай байгуулж, байгалийн нөөц ашигласны төлбөрийг сумдын “тусгай данс”-нд төвлөрүүлсэн.

6. Төслийн талбайгаас 1664.94м³ энгийн, 140.496м³ аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах зөвшөөрөлтэй эрх бүхий “Тэгш дүүрэн тохижилт”, “Ханбогд вэйст менежмент центр” ОНӨААТҮГ-үүдтай байгуулсан гэрээний дагуу орчны бохирдол, кемпүүдийн ахуйн болон аюултай хог хаягдал түр хадгалах цэг, хадгалалтын сав, тээвэрлэлтэд хяналт тавьж ажилласан.

7. Засгийн газрын 92-р тогтоолоор хил холболтын хэсгийн төмөр замын шугамын чигийг батлагдсантай холбогдуулан төмөр замын дагуух эзэмшил газрын талбайд өөрчлөлт оруулах хүсэлтийг хүргүүлж, Ханбогд сумын Засаг даргын А/38 тоот захирамжаар “Төмөр замын эзэмшил газрын талбайн хэмжээ”-нд өөрчлөлт оруулж батлуулсан.

8. Баян-Овоо сумын нутагт байрлах YII радио цамхагийн 1.44 га талбайн газар эзэмших эрхийг Баян-Овоо сумын Засаг даргын 2022.07.01-ний өдрийн А/51 дугаартай “Газар эзэмших эрх олгох тухай” захирамжаар гаргуулан авч баталгаажуулсан.

9. Цахилгаан эрчим хүчний Манхан дэд станцын ашиглалтын талбай болох 0,68га газрыг эзэмших эрхийн захирамж, гэрчилгээг Өмнөговь аймгийн Ханбогд сумаас гаргуулан авч, газар ашиглах гэрээг цахимаар байгуулсан.

10. Ханбогд, Цогт-Цэций, Баян-Овоо сумын нутаг дэвсгэрт төмөр замын трассын дагуу суурьшиж буй 12 айл өрх, иргэд судалгаанд хамрагдсан, орон нутаг хариуцсан ажилтнууд иргэдтэй ярилцаж, тэдний санал бодлыг сонссон байна.

11. ПК25+000-ПК225+000 хоорондох үндсэн болон түр репперүүдийн түвшинг шалгаж баталгаажуулсан, “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын дээд бүтцийн барилга угсралтын ажлын геодезийн хяналтын ажлыг хийж гүйцэтгэсэн,

12. Нүүрс ачилтын тойрогт хийгдэх нүүрс ачиж, буулгах 100*1200 м харьцаатай Түр ачилтын талбайн байр зүйн зураглал хийн боловсруулсан. Phantom RTK v2 дроноор хийсэн агаарын зураглалыг Agisoft программаар боловсруулж үр дүнг RUIDE маркийн 2 долгионы GPS-ийн хэмжилтийн үр дүнтэй харьцуулж өндрийн зөрүүг гаргах дүнд шинжилгээ хийсэн,

13. Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн холболтын төмөр замын болон Гашуунсухайт өртөөний шилжүүлэн ачих терминал, өртөөний тойрог замын урд хэсэгт байгуулах нүүрс ачих түр ачилтын талбайн зураг төсөл,

15. “Богдхан” төмөр замын чигийн хайгуул, судалгааны зураг төсөл зэрэг ажлууд хийгдэж ирсэн байна.

Өмнөговь аймгийн Цогт-Цэций, Ханбогд, Баян-Овоо сумын нутаг дэвсгэрийн дагуух “Тавантолгой-Гашуунсухайт”, “Тавантолгой-Зүүнбаян” чиглэлийн төмөр замын холболтын төмөр замын трасс ба түүний орчим хийгдсэн **соёлын өвийг хамгаалах судалгааны үр дүнгийн** талаарх ШУА-ийн Археологи, Палеонтологийн хүрээлэнгийн мэдээ, тайланд сууриссан 2021, 2022 оны зам, барилгын ажлууд хийгдэж, энэ оны 5 дугаар сараас эхэлсэн “Богдхан” төмөр зам төслийн археологи, палеонтологийн хайгуул судалгааны ажлын тайлан, мэдээллийг дээр дурдсан хүрээлэнгүүд цаг хугацаанд ирүүлж байна.

Компанийн **нийгмийн хариуцлагын хүрээнд** энэ оны 6 дугаар сард Цогтцэций сумын Ерөнхий боловсролын 1, 2 дугаар сургуулийн 9, 12 дугаар ангийн төгсөгчидтэй уулзалт зохион байгуулж, төмөр замын мэргэжлийн онцлог, давуу талын талаарх ойлголт, мэргэжил сонголтыг сурталчлах ажлыг зохион байгуулж, нийт 96 суралцагч, нийгмийн ажилтан, багш нар оролцсон байна.

Дөрөв. Суурь бүтцийн үйл ажиллагаа, түүний хэрэгжилт

Барилга угсралтын ажил гүйцэтгэх төлөвлөгөө, түүний биелэлт, чанарт хяналт тавих:

- Ерөнхий гүйцэтгэгч барилга угсралтын ажил гүйцэтгэх мастер төлөвлөгөөг боловсруулж, танилцуулсан ба “Кovid-19” цар тахлаас шалтгаалан мастер төлөвлөгөөнд 4 удаагийн өөрчлөлт оруулж, 2021.06.10-нд ирүүлсэн BI-TTGS-WBS-0003 тоот мастер төлөвлөгөөг баталж, барилга угсралтын ажлыг гүйцэтгүүлсэн;
- 2022.06.16-ны өдөр BI-TTGS-WBS-0004 тоот мастер төлөвлөгөөг ирүүлсэн, энэ нь BI-TTGS-WBS-0003 тоот мастер төлөвлөгөөнөөс зөрүүтэй байсан тул татгалзаж, “мастер төлөвлөгөө”-нд тусгагдсан зарим ажлууд хугацаа хэтэрсэн тул ажилбаруудын алдагдсан хугацааг нөхөж ажиллах талаар захиалагчийн шаардлага хүргүүлсэн;
- Төлөвлөгөөнд туссан ажлуудыг нөхөн ажиллах зохион байгуулалт, менежментийн арга хэмжээг авч, тухайн ажлыг зураг, техникийн нийцүүлэн батлагдсан ажил гүйцэтгэх аргачлалын дагуу гүйцэтгэж байгаа эсэхийг шалган ажилласан;
- Барилга угсралтын ажилд ашиглагдаж буй бараа материал, газар широо болон бетоны ажилд ашигласан дүүргэгч материалын чанарт хяналт тавьж ирсэн;
- Барилга угсралтын ажил нь дууссан ажлууд (замын доод, дээд бүтэц; дохиолол холбоо, эрчим хүч, барилга байгууламжууд)-ыг хэсэгчлэн шалгаж, хүлээн авах боломжтой эсэх талаар дүгнэлт гаргасан;
- Барилга угсралтын ажлын бэлэн болсон замын дээд, доод бүтэц, дохиолол холбоо, эрчим хүч, технологийн барилга байгууламжууд дээр ЗТХ-ийн сайдын 2021.12.23-ны өдрийн A/196, 2022.04.21-ний өдрийн A/106, 2022.06.06-ны өдрийн A/152, 2022.08.31-ний өдрийн тушаалууд, ЭХ-ний сайдын A/152 тушаалаар техникийн комиссын гишүүдийг ЗТХЯ, ЭХЯ, БХЯ, ОБЕГ, АЕГ, ГТХЗНТ, ЦДУС зэрэг газрууд болон Өмнөговь аймгийн засаг даргын A/779 дугаар захирамжаар байгуулагдсан улсын комисс:

1. Тавантолгой өртөө, Гашуунсухайт өртөө, Ачилтын тойрог болон 1, 2, 3, 4, 5, 6-ын зөвлөгийн дээд, доод бүтэц, дохиолол холбоо, технологийн барилга байгууламж, эрчим хүчний чиглэлээр дүгнэлт гарган, байнгын ашиглалтад хүлээн авсан;
 2. Техникийн комисс ачилтын тойроос 226.670 дугаар км хүртэл төмөр замын дээд болон доод бүтэц, тавантолгой өртөөний барилга байгууламжууд, 1, 2, 3, 4, 5, 6 зөвлөгийн удирдлагын байр, ажилчдын орон сууц, ачилтын тойрог, радио холбооны байгууламж болон Манхан, Зэрэглээ дэд станцуудыг ашиглалтад хүлээн авч, эрчим хүчний хүчдэл залгах шийдвэр гарган ажиллаж, байнгын ашиглалтад хүлээн авсан;
 3. Өмнөговь аймгийн засаг даргын 2022 оны A/999, A/1278, A/1649 дүгээр захирамжаар Тавантолгой өртөөний техникийн 6 барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авсан;
- Гашуунсухайт өртөөний технологийн 7 барилга байгууламжийн гүйцэтгэл 62 хувьтай хэрэгжиж байна.
- “Тавантолгой-Гашуунсухайт ба Тавантолгой-Зүүнбаян” чиглэлийн холболтын төмөр замын төсөлт ажлууд:
- Төмөр замын доод бүтцийн зам, барилга угсралтын ажил бүрэн дууссан ба дээд бүтцийн барилга угсралтын болон бараа материал нийлүүлэлтийн ажил хийгдэж байна.
 - ЗТХ-ийн сайдын 2022.06.06-ны өдрийн A/152, 2022.08.31-ний өдрийн A/239 дүгээр тушаалаар томилогдсон техникийн комисс ажиллан, нэмэлт үүрэг даалгавар өгсөн ажлын хүрээнд хэрэгжилтийг ханган ажилласан.
 - Техникийн комисс уг холболтын төмөр зам дээгүүр тодорхой хурдтайгаар хөдлөх бүрэлдэхүүн явуулж болох дүгнэлт талбай дээр өгсөн бөгөөд албан ёсны дүгнэлтийг гарахаар хүлээгдэж байна.

Явц дундын төлбөрийн хүсэлтийн дагуу гүйцэтгэлийн тоо хэмжээг шалгасан баталгаажуулалт:

- Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн холболтын төмөр замын төслийн хүрээнд нийт 15 удаагийн явц дундын төлбөрийн хүсэлт баталгаажуулах 22,192 хуудас бүхий баримт бичигт тулгуурлан гүйцэтгэлийг хянаж тоо хэмжээг баталгаажуулсан
- Гүйцэтгэлийн материалыудыг архивын техникийн заалтын дагуу архивлаж хадгалсан ба явц дундын төлбөрийн хүсэлтээр ирүүлсэн баримт материалд гүйцэтгэсэн ажлын ил, далд ажлын акт үйлдэж, баталгаажуулсан;
- Бүх бараа материалын чанаарын баримт бичиг тэдгээрийн дагалдах паспорт, гэрчилгээг шалгах, гүйцэтгэгдсэн ажлууд техникийн ерөнхий шаардлага, ажлын зураг төсөл, ажил гүйцэтгэх аргачлалын дагуу хийгдсэн эсэх талаар тэдгээрийг батлах баримт бичгийн бүрдэл, гүйцэтгэсэн ажлыг газар дээр нь үзлэг, хэмжилт хийж тулгах зэрэг болно.

Төмөр замын ашиглалт үйл ажиллагааны чиглэлээр:

Ачилтын тойрог, холболтын төмөр замын 21 км, Тавантолгой өртөөс Гашуунсухайт өртөө хүртлэх замын арчлалтын ажлыг гүйцэтгэн ажилласан,

Зэрэглээ, Манхан дэд станцуудын хүчдэлийг залган тоног төхөөрөмжийн 72 цагийн туршилтыг явуулж, ашиглалтын үед эрчим хүчээр тасралтгүй хангах бэлтгэл ажил хийгдсэн,

Тоног төхөөрөмж реле хамгаалалтад туршилт тохируулгыг хийж, “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын хүрээнд эрчим хүчээр ханган ажилласан, мөн төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах зурvas газрын хориг хашааг таслах, хориг хашааны хаалгыг эвдлэх, мал, ан амьтан орох гаргах болон хориг хашааг сэргээн засварлаж ажилласан,

Инженер, техникийн ажилчдын харилцаа холбоог сайжруулах зорилгоор тетра радио, холбооны тоон радио гар станцуудыг ажилтнуудад хуваарилан өгч, Тавантолгой өртөө, Оюут, Шинэ-Ус зэрлөгийн хамаарлыг диспетчерийн удирдлагад шилжүүлж, ОСС болон хяналтын дэлгэц, холбон байнгын ашиглалтад оруулсан зэрэгт хяналт тавьж ажиллаж байна.

Тав. Санхүү, төлөвлөлтийн талаар

1. Санхүү, төлөвлөлт, хөрөнгө оруулалт, худалдан авалтын төсвийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, үйл ажиллагааны зардал, хөрөнгө оруулалт төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайланг дараа сарын 5-ны дотор гаргаж, улирал тутамд ТУЗ болон Гүйцэтгэх захиралд, 2022 оны явцын аудитын багт холбогдох төсөв, төсвийн гүйцэтгэлийг тухай бүр гарган тайлагнаж ажилласан,
2. 2021 оны санхүүгийн тайлангийн аудитлагдсан тайланд 2022 оны 4-р сарын 1-ний өдөр албан шаардлага 3, зөвлөмж 6, залруулга 4 ирүүлснийг заасан хугацаанд биелэлтийг гаргаж СЯ, УУХҮЯ, УАГ болон "Эрдэнэс Тавантолгой" ХК-д хүргүүлсэн.
3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах болон бүтэц, орон тооны дээд хязгаарыг хавсралт ёсоор шинэчлэн батлуулж, дэд захирал болон зөвлөхүүдийн орон тоог хасаж, 883 ажилтны орон тоотойгоор ажиллаж байна.
4. Санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор нийт 10 бүлэг, 28 зүйл бүхий ажлын төлөвлөгөө батлуулж, Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын дагуу 629,190,700.0 ширхэг хувьцааг эргэлтэд нэмж гарсан хувьцааг бүртгэн, дүрмийн өөрчлөлтийг холбогдох төрийн байгууллагад бүртгүүлсэн байна.
5. "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил худалдан авах тухай" хууль, "Төрийн хэмнэлтийн тухай" хууль болон холбогдох журмын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, "Тавантолгой-Гашуунсуухайт" чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад бий болсон хөрөнгийг хүлээн авч, бүртгэх ажлыг гүйцэтгэсэн.
6. "Тавантолгой-Гашуунсуухайт" чиглэлийн төмөр замын тээврийн үйлчилгээний үнэ, тариф, тарифын болон холбогдох бусад дүрэм, журам, горим /заавар/-ын төслийг боловсруулж, "Эрдэнэс Тавантолгой" ХК болон ЗТХЯ-д хүргүүлэн ажилласан.
7. Тээврийн үйл ажиллагаа эрхлэлтийн Нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг судлан, Олон улсын санхүүгийн болон Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа холбогдох хууль тогтоомж, стандартад нийцүүлэн судалгаа хийсэн.
8. "Тавантолгой-Гашуунсуухайт", "Тавантолгой-Гашуунсуухайт ба Тавантолгой-Зүүнбаян", "Богдхан" төмөр зам, "ТНАЛТ", "ШАТ" зэрэг төслүүдийн тээвэрлэлт, суурь бүтцийн 2 үндсэн үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт, ажлын гүйцэтгэл, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн, явц дундын төлбөрийн бүртгэлийг хийж, захиалагчийн хяналтын зардлыг хуваарилж бүртгэсэн.
9. "Тавантолгой-Гашуунсуухайт" чиглэлийн төмөр замын төслийн барилгын ажил дуусаж байгаатай холбогдуулан гэрээ хаах, ажил хүлээлцэх, дуусаагүй үйлдвэрлэлийг хөрөнгөд бүртгэх, бараа материалын бүртгэл, санхүүгийн тайлан бүртгэлийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.
10. "Тавантолгой-Гашуунсуухайт", "Тавантолгой-Гашуунсуухайт ба Тавантолгой-Зүүнбаян", "Богдхан" төмөр замын болон "ТНАЛТ", "Шилжүүлэн ачих терминал" зэрэг төслүүдийн хөрөнгө оруулалт, ажлын гүйцэтгэл, захиалагчийн хяналтыг СТОУС, НББОУС болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн санхүүгийн бүртгэлийг хөтөлж ажилласан.

Зургаа. Тээвэр, удирдлагын үйл ажиллагаа

"Тавантолгой-Гашуунсуухайт" чиглэлийн төмөр замын тээвэр, зохион байгуулалтын ажлыг бусад салбарын үйл ажиллагаатай нягт уялдуулж, ачаа – тээвэр, логистикийг оновчтой зохион байгуулах, тээвэрлэлттэй холбоотой баримт бичиг, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, зохицуулах, биелэлтийг хангуулан ажиллаж, захирлын А/50 тушаалаар баталсан "Тавантолгой-Гашуунсуухайт" чиглэлийн төмөр замын тээвэрлэлтийн бэлтгэл ажлыг хангах тухай шийдвэр, түүний мөрөөр авах арга хэмжээний 125 нэр төрлийн ажил, үйлчилгээ 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хөдөлгөөн, зохион байгуулалт, ачаа тээвэр, логистик

- “Төмөр замын тээврийн тухай хууль” болон ЗТХ-ийн сайдын 2020 оны А/154 тоот тушаал, төмөр замын тээвэр эрхлэхэд холбогдох бусад тушаал шийдвэрийн хэрэгжилтийг хангах, суурь бүтэц эзэмшигч тогтоох журам, заавар, аргачлалын жагсаалтын дагуу нийт 27 журам, зааврыг Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, журамд нийцүүлэн боловсруулж мөрдөн ажиллаж байна.
- Техникийн бичиг баримт, ажлын багаж хэрэгслүүдийг захиалан авч, үйл ажиллагаандaa бүрэн ашиглаж, гүйцэтгэх захирлын баталсан 12 тушаал, зааврыг мөрдөн ажиллаж байна.
- Туршилтын тээвэр эрхлэхтэй холбогдуулан өртөө, зөрлөгийн ажилчдад төмөр замын төслийн талаар болон компанийн хэмжээнд мөрдөгдөж буй тушаал, зааврын талаарх сургалтыг 36 удаа явуулсан.
- Тавантолгой өртөө, удирдлагын байрны барилга болон 1, 2, 3, 4, 5, 6 зөрлөгийн барилга, дохиолол холбоо, түүний цамхаг, цахилгаан хангамж, төвлөрүүлэлт хориглолын байгууламж, гадна зам, талбай, гэрэлтүүлгийг комисст хүлээлгэн өгсөн.
- УБТЗ ХНН-ийн Загал 002, 003 илчit тэргийг түрээслэн Тавантолгой-Гашуунсуухайт, Тавантолгой-Цогтцэций чиглэлд туршилтын тээвэр, зүгшрүүлэлт хийж, ГТХЗНТөв ТӨҮГ-ын нэгдсэн зурмагт өвлийн галт тэрэгний хөдөлгөөний зурмагийг тусгаж батлуулан, үндсэн тээврийн үйл ажиллагаанд бэлтгэсэн.
- Төмөр замын нээлтийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу анхны 2050 дугаар галт тэрэгний аялалыг аялуулж, тээврийн үйл ажиллагааг эхлүүлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар тэгш сондгой чиглэлийн ачааны болон аж ахуйн галт тэрэг нийлсэн 445 галт тэрэг аялуулан, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулж байна.
- Хөдөлгөөн зохион байгуулалтын хэмжээнд хөтлөгдөх 5 төрлийн 5000 ширхэг маягт, 3 төрлийн 300 ширхэг зурмаг, 14 төрлийн 380 ширхэг дэвтэр хэвлүүлж, үйл ажиллагаандaa ашиглаж байна.
- Тээвэрлэлтийн ажилд шаардлагатай журам, дүрэм боловсруулах, хөтлөгдөх дэвтэр, маягтын загварыг бүрэн боловсруулж, ажилтнуудын албан хэрэгцээнд ашиглах гарын авлага, Тавантолгой өртөө, Гашуунсуухайт өртөөний ажилтан, үйлчлүүлэгчид зориулсан тарифын болон мэдээллийн самбарыг ашиглаж байна.
- Өртөө, терминалын ажлын байранд шаардлагатай хатуу тооцоот багаж болон оосорлох болон бэхэлгээний хэрэгсэл, бууршгүй нөөцийн жагсаалтыг бэлэн болгож, ашиглах бланкны жагсаалтыг гаргаж, ачаа тээвэрлэлтийн өдөр тутмын үйл ажиллагаа, орлого бүрдүүлэлтэд хяналт тавих 15 төрлийн дэвтрүүдийн загваруудыг үйл ажиллагаандaa ашиглаж ирсэн.
- Хагас болон тавцант вагон дээр чингэлэг /дээвэргүй/ ачих техникийн нөхцөлийг батлуулж, ашиглах заавар, технологийн горим, технологийн карт, гэрээний загварууд, ачаа хамгаалах журам, санамж хөтлөх журмыг бусад газар, хэлтсүүдэд хүргүүлэн ашиглаж байна.
- “ГТХЗНТ” УТҮГ-аас ирүүлсэн 241 тоот арга зүйн зөвлөмж хүргүүлэх тухай албан бичгийн дагуу Олон улсын төмөр замуудын холбоо /ОУТЗХ/-нд байгууллагын код авах хүсэлт гарган, 6 дугаар сарын 20-ны өдөр 5083 кодыг албан мэйлээр хүлээн авсан.
- Тээврийн аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагаа эрхлэх эрхийг УБТЗ болон хөрш орнуудын төмөр замуудад зарлуулсан, ЗТХЯ-наас “TYA/076-2021 дугаартай төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл”-ийг 3 жилийн хугацаатай авсан.
- ЗТХЯ, “Эрдэнэс Тавантолгой” ХК-д ачаа тээвэрлэх тарифын мөрдлөгт санал авах 1/623 тоот албан бичиг хүргүүлж, ЗТХЯ-наас 1/2853 тоот албан бичгээр тарифын саналыг ирүүлсэн. Үүнийг үндэслэн Гүйцэтгэх захирлын А/84 тоот тушаалаар “Суурь бүтэц ашиглуулах, тээврийн үйлчилгээний тариф батлах тухай” шийдвэр гарч, тарифын 1 болон 2 дугаар мөрдлөг, мөн 8 дугаар сарын 3-ны өдөр Тарифт хөнгөлөлт үзүүлэх тухай А/135 тоот тушаал гарсан.
- ТНАЛТ-ыг төлөвлөгөөний дагуу 2023 оны 12 дугаар сард ашиглалтад өгөх, уг тойрог замын урд хэсэгт нүүрсийг автоачигч /ковш/-аар ачих механикксан ·терминал байгуулахаар ажиллаж байна.

- “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 9 га газарт түр ачилтын талбай байгуулж, ашиглалтад оруулсан. Түр ачилтын талбайгаас нүүрс болон мидлинг ачилтын үйл ажиллагааг чингэлэг ачигч болон ковшоор гүйцэтгэх ажлыг “Эрдэнэс Тавантолгой” ХК зохион байгуулж, ачаа тээврийн хяналтыг тээврийн инженерүүд хэрэгжүүлж байна.
- “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлд 12 дугаар сарын 11-ны өдрийн байдлаар 112698 тонн нүүрс, “Тавантолгой-Цогтцэций” чиглэлд уурхайгаас 98400 тонн мидлинг тус тус тээвэрлэж, тээвэрлэлтийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

Зүтгүүр ба вагоны аж ахуйн үйл ажиллагааны талаар

- Үйл ажиллагаанд мөрдөх 20 журам 5 технологийн горим 5, авто тормосын зааврыг боловсруулж, тээврийн үйл ажиллагаанд холбогдох бичиг баримтыг ЗТХЯ-нд хүргүүлэн “Зүтгүүрийн техник үзлэг, үйлчилгээ” хийх зөвшөөрлийг авсан.
- Төслийн гэрээний дагуу SD70Ae/LW, сэлгээний 2GS16C зүтгүүрүүд /2022.04.07/-ийг “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ-ын хөдлөх бүрэлдэхүүний мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлж, дугаар авсан байна.
- УБТЗ ХНН-тэй 23АГАЛ серийн 2 ширхэг зүтгүүрийг түрээслэх гэрээ байгуулж, гэрээний нэмэлттээр 12-р сарын 31-нийг хүртэл сунгаж, дахин нэмэлт өөрчлөлтөөр 1 секцийн М62ҮМм серийн илчit тэргийг ашиглаж байна.
- 2022.11.14-ний өдрийг хүртэл 207 галт тэрэг аялсан, “УБТЗ” ХНН-тэй байгуулсан зүтгүүр түрээслэх гэрээ энэ сарын 31-нд дуусч байгаатай холбоотойгоор тээврийн ажлыг зогсоохгүй байх үүднээс зүтгүүрийн түрээсийн гэрээг үргэлжлүүлэх, цаашид нэн яаралтай зүтгүүр худалдан авах асуудлыг судалж байна.
- Төслийн ЕРС гэрээний багц-5 [хөдлөх бүрэлдэхүүн]-д заасан 810 ширхэг ачааны вагоныг хүлээн авах, үүнээс 100 хагас вагон /12-9853/, 250 тавцант вагон /13-6724/-ыг хүлээн авсан, вагон хүлээн авалтын явц 43.3 хувьтай байна.
- Гэрээний (ЕРС) багц 6 [хөдлөх бүрэлдэхүүний засварын тоног төхөөрөмж]-д заасан вагон засварын депод угсрагдах 139 тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлтийг хянан баталгаажуулж, захиалагчийн хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд гүйцэтгэгч талаас тоног төхөөрөмж худалдах, худалдан авах гэрээг бүрэн байгуулсан тухай мэдээллийг ирүүлсэн.
- ЕРС гэрээний багц-6 [хөдлөх бүрэлдэхүүний засварын тоног төхөөрөмж] “Багаж болон бусад” хэсэгт орсон 92 нэр төрлийн 936 ширхэг багаж, 147 нэр төрлийн 404 ширхэг хэмжих хэрэгслийг Тавантолгой кемп /TGHU 289172 дугаартай чингэлэг/-д Санхүү, төлөвлөлтийн газар хүлээн авч, бүртгэлжүүлсэн.

Долоо. Үр дүнгийн талаар

1. Олон улсын түвшинд нийцсэн төмөр замын үйлчилгээ эрхлэх чадавхтай, үндэсний тэргүүлэх байгууллага болохын тулд төсөл бурийн онцлог, зүй тогтол, нөхцөл байдалд нийцүүлэн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлсэн.

2. “Төслийн удирдлагын үйл ажиллагаанаас төмөр замын ашиглалт, тээвэрлэлтийн цогц үйлчилгээ үзүүлдэг” компани болж өсөн дэвших зорилт, зорилго тавьж, хөгжлийн бодлогын баримт бичиг болох “Стратеги төлөвлөгөө - 2050”, “Тээврийн хөгжлийн хөтөлбөр - 2050”-ийн I шатны ажил, үйлчилгээг хэрэгжүүлж ирсэн.

3. Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд “гацсан” төмөр замын бүтээн байгуулалтын томоохон төслийг хөдөлгөж, бие даан техник эдийн засгийн үндэслэл, тооцооллыг гаргаж, бодит ажил хэрэг болгож, энэ оны 9 дүгээр сарын 9-нд албан ёсны нээлт хийж, тээврийн үйл ажиллагаа эрхлэх боломжийг бүрдүүлсэн.

4. “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Бoomтын сэргэлтийн хүрээнд Монгол Улсын “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой төмөр зам” ХХК болон БНХАУ-ын “Чайна Энержи” ХХК-ийн хооронд “Гашуунсухайт-Ганцмод боомтын төмөр зам болон нүүрс худалдах, худалдан авах ерөнхий хэлэлцээр”-ийг байгуулж, энэхүү төслийн хэрэгжих боломж бүрдсэн.

5. “Гашуунсухайт-Ганцмод” хилийн боомтыг төмөр замаар холбох ажлын техник эдийн засгийн үндэслэл, ажлын нарийвчилсан зураг, төслийг Хятадын төмөр замын зураг төслийн хүрээлэнтэй хамтран гүйцэтгэх гэрээ байгуулж, манай тал урьдчилсан санхүү хөрөнгийг гаргахаар тохиролцсон.

7. Гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллагуудтай олон төрлийн арилжааны гэрээ, хэлэлцээрийг Монгол улсын хууль тогтоомж болон олон улсын худалдааны практикт өргөн хэрэглэж байгаа олон улсын эрх зүйн баримт бичгүүдийн үндсэн дээр байгуулах түвшинд бид олон улсын зөвлөх инженерүүдийн холбоо (**ФИДИК**)-оос хэвлүүлсэн “**Түлхүүр гардуулах төслийн инженеринг, худалдан авалт болон барилгын гэрээний нөхцөл, 1999 оны анхны редакц** (Conditions of Contract for EPC/Turnkey Contract, First Edition 1999)” баримт бичиг”-ийг Монгол хэл рүү оруулж, үйл ажиллагаанд ашиглаж байна.

8. “Тавантолгой-Гашуунсухайт болон Тавантолгой-Зүүнбаян” чиглэлийн холболтын төмөр зам, “ШАТ”, “ТНАЛТ”, “Богдхан” төмөр зам зэрэг төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг инженер, техникийн ажилтнуудын мэргэжлийн мэдлэг, нөөцөд тулгуурлан боловсруулж, эрх бүхий байгууллагаар магадлуулах ажлыг хийлгэж, дээрх ажлуудыг МН/01, МН/03, МН/28 шийдвэрийн дагуу Гүйцэтгэгч компаниудтай барилга угсралтын ажлын гэрээ болон ЕРС буюу түлхүүр гардуулах гэрээг байгуулсан.

9. Санхүү, нягтлан бodoх бүртгэлийн ажил гүйлгээг холбогдох хууль, дүрэм, журам болон СТОУС-ын дагуу хөтлөх, санхүүгийн тайлан, татвар, нийгмийн даатгалын тайланг тайлагнах, шилэн данс хөтлөлтийг хэрэгжүүлэх, бусад холбогдох тайланг хуулийн хугацаанд гаргах ажил тогтмолжсон, Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмжк, үүрэг даалгаврын хүрээнд тусгайлсан төлөвлөгөө, хөтөлбөр гарган батлуулж ажилласны үр дүнд 2021 оны жилийн эцсийн тайланг аудитаар баталгаажуулж, “**стандарт**” үнэлгээ, дүгнэлт авсан.

10. Компанийн үйл ажиллагаанд 2020, 2021, 2022 онуудад ISO9001:2015, ISO 27001:2013, ISO21500:2012, ISO14001:2015, ISO45001:2018 олон улсын стандартуудыг тус тус нэвтрүүлж, олон улсын баталгаажилтын гэрчилгээг хүлээн авсан.

Найм. Зөвлөмж

1. Бүтэц, орон тооны дагуу ажлын байрны давхцал, ажил үүргийн хуваарилалт, түүний запруулалт, нэн шаардлагатай ажиллах хүчиний нөөцийг нөхөж болон хавсарч ажиллаж болох талаарх судалгаа, тооцоог газар, хэлтэс /нэгж/-ээр хянаж ажилласан эсэх талаар тайланда тусгаагүй, дүгнэж үзээгүй байгаад анхаарч ажиллах;

2. Байгууллагын хүний нөөцийн бодлогын бичиг баримтын хэрэгжилтийн үе шатад үнэлгээ, дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан ажлын хэрэгжих хугацаа, хүрэх үр дүнг оновчтой тодорхойлох, асуудлыг мэдээлэл, судалгаанд суурилан боловсруулж, ажиллах;

3. Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр болон сургалт, мэдээлэл, хамтын ажиллагаанд өмнөх онуудын мэдээллийг давхардуулан ашиглахгүй байх, хэвлэл мэдээллийн урсгалын зүй тогтол, мөн чанар, ач холбогдлыг илүүд авч үзэх, сэтгүүл зүйн ухааны үүднээс асуудалд хандах, мэдээллийн өрсөлдөөнд хүмүүсээ сургах, дадал, чадвар эзэмшүүлэхэд анхаарах, цаг тухайд нь олон нийтэд мэдээ, мэдээллийг хүргэх, үр дүнд мониторинг хийх, дүгнэлт судалгаатай хандаж байх;

4. Тушаал шийдвэр, түүний гүйцэтгэлийн хувь хэмжээ болоод гүйцэтгэл дутуу тушаал шийдвэрийн учир шалтгааны талаар тодорхой санал, дүгнэлттэй хандаж байх, байгууллагын ажлын үр дүнд чухал болохыг бодолцох;

5. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлийг дэлгэрэнгүй тайлагнах шаардлагатай бөгөөд цахим хуудсанд оруулаагүй мэдээллийн талаарх тайлбарыг дурдаж байх, байршуулснаас өөр мэдээллийг тайлагнаагүй байдалд дүгнэлт хийх;

6. Төмөр замын гол шугамын дагуух аюултай бүсийн хориг хашааг мал амьтан орохгүйгээр бүрэн хашаажуулах ажлыг зохион байгуулж дуусгах;

7. Хос дугуйн парктай болох ажлыг шийдвэрлэх, өртөө - зөрлөг хоорондын хагас автомат хориглолын дохиолол, зам сумыг ажилд оруулах, өртөөний жижүүр ба зүтгүүрийн машинч нарын хооронд ярих радио станцаар бүрэн хангах, ажиллагааны найдвартай байдлыг бий болгох;

8. Тавантолгой өртөөний хөдлөх бүрэлдэхүүн, депогийн ажил удаашралтай явагдаж байгаад дүгнэлт хийх, түрээсээр авч ашиглаж буй зүтгүүр ТО-2-т техник үзлэг, үйлчилгээ хийх боломжийг нэн даруй бүрдүүлэх, түрээсийн төлбөр тооцоог цаг хугацаанд шуурхай шийдвэрлэж байх;

9. Түрээсийн илчit тэргэнд хэрэглэгдэх засварын сэлбэг, багаж хэрэгсэл, тос тоослох

материал, элс болон бусад материалаар хангагдаагүй байгааг анхаарч, холбогдох шийдвэр гаргах.

10. “УБТЗ” ХНН, “Болдтөмөр өрөө гол” ХХК-д ашиглагдаж байгаатай ижил төстэй хөдөлгөөн, ачаа тээвэр, зүтгүүрийн бүртгэлийн 5 программыг болон эсхүл олон улсад ашиглагдаж буй программыг худалдан авах замаар компанийн тээвэрлэлтийн анхан шатны бичиг баримт, мэдээ - тайлангийн боловсруулалт, томъёо, тооцоололд ашиглах, харьцуулах, баталгаажуулах ажлыг өндөр түвшинд гүйцэтгэх боломжийг бурдуулэх.

11. “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн тэмөр замын бүтээн байгуулалтын ажил (зүтгүүр, вагон нийлүүлэх)-ыг дуусгахад шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэх, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд анхаарч ажиллах.

12. Вагон депогийн тоног төхөөрөмжийн суурилалт, ашиглалт, туршилтын сургалтын ажлын бэлтгэлийг сайтар хангах, үүнд ажиллах хүний нөөцийг бүрдүүлэхэд анхаарах,

13. Тээврийн зардлыг төслийн захиалагчийн хяналтын зардлаас санхүүжүүлж буй байдлыг зогсоох, тээвэрлэлтийн үеийн мөнгө - хөрөнгийн болон өөр эх үүсвэрийг ашиглах бодлогыг баримтлах.

14. Санхүү, төлөвлөлтийн тайлан, мэдээнд ЕРС гэрээнд туссан маш нууц болон нууцын зэрэглэлд үл хамаарах зарим тоон үзүүлэлтийг график, диаграммаар тодорхой, ойлгомжтой байдлаар харуулж, үр дүнг Гүйцэтгэх захирлын Зөвлөлийн хуралд улирал тутамд танилцуулж байх журамд шилжих,

15. Газар, хэлтэс /нэгж/-үүд ажлын тайлангаа улирал, хагас, бүтэн жилээр нэгтгэн ЗҮГ үнэлгээ, дүгнэлт өгч, компанийн жилийн эцсийн тайланд 12 дугаар сарын 15-ны дотор хяналт шинжилгээ хийлгэсэн дүнг Гүйцэтгэх захирал болон Төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлж байх,

16. “Жилийн эцсийн тайлан”-г хамт олноор ил тод хэлэлцүүлж, үр бүтээлтэй ажилласан, ажил мэргэжилдээ амжилт гаргасан ажилтан, ажилчдыг Гүйцэтгэх захирлын болон салбарын, төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр шагнаж, урамшуулах ажлыг тогтмолжуулахыг тус тус зөвлөж байна.

Компанийн үйл ажиллагааны нэгдсэн тайлан, төлөвлөгөөнд хийсэн хяналт шинжилгээ, үр дүнгээс үзэхэд **2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөт** ажлын биелэлт 91.2 хувьтай байгаа тул “хангалттай сайн” гэж үнэлж дүгнэв.

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД
АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА

Б.ЭНХБАТ